

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД ХИЙДСЭН
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫН НИЙТИЙН
СОНСГОЛЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 10 дугаар сарын 30

№ 02

Хужирт сум

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийдсэн ажил, арга хэмжээний гүйцэтгэл” сэдвийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 14:00 цагт сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд хуралдав.

Хуралд оролцогчоор П.Мандахбаяр, С.Янжинцэвэл, М.Энхтуяа нар, ажиглагчаар Х.Мөхзул, Л.Туяа, Д.Хоролсүрэн, Ч.Цэвэлмаа нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийдсэн ажил, арга хэмжээний гүйцэтгэл”

СОНССОН НЬ:

Т.Даваадорж: Энэ удаагийн Нийтийн сонсголд хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа. Нийтийн сонсгол гэдэг нь төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдийн хяналтыг сайжруулах үүрэгтэй ийм үйл явц юм.

Төсвийн хяналтын сонсголыг хуулийн дагуу тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр зохион байгуулдаг. Өнөөдрийн сонсголоор “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийдсэн ажил, арга хэмжээний гүйцэтгэл”-ийн тайланг танилцуулна.

Дуудагдаж ирсэн албан тушаалтануудыг танилцуулъя.

Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дэмбэрэл, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Уранчимэг, Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Г.Оюунмандах нар хүрэлцэн ирсэн.

Оролцогчоор 4 дүгээр багийн иргэн П.Мандахбаяр, 4 дүгээр багийн иргэн С.Янжинцэвэл, 4 дүгээр багийн иргэн М.Энхтуяа нар, ажиглагчаар 4 дүгээр багийн иргэн Х.Мөхзул, 3 дугаар багийн иргэн Л.Туяа, 1 дүгээр багийн иргэн Д.Хоролсүрэн, 2 дугаар багийн иргэн Ч.Цэвэлмаа нар ирсэн байна.

Оролцогч нар тухайн мэдээлэлтэй холбоотой саналыг хэлнэ, асуултыг асууна. Ажиглагчаар оролцож байгаа хүмүүс бол асуулт асуух эрхгүй, санал хэлэх эрхгүй, зөвхөн энэ үйл ажиглагааг ажиглах үүрэгтэй оролцоно.

Ингээд та бүхэнд нийтийн сонсголын дэгийг танилцуулъя. (Дэгийг хавсаргав)
За Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Г.Оюунмандах тайланг танилцуулна уу.

Г.Оюунмандах: За та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэндээ Хужирт сумын “2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, төсвийн гүйцэтгэл”-ийг танилцуулъя. (Тайланг хавсаргав)

Т.Даваадорж: Оролцогчдыг танхимд ирсэн дарааллын дагуу саналаа хэлж, асуултаа асуухыг хүсэж байна. За дарааллын дагуу П.Мандахбаяр эгч “2022 оны

орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний гүйцэтгэл"-ийн тайлантай холбоотой асуух асуулт байвал асуугаарай.

П.Мандахбаяр: 4 дүгээр цэцэрлэгийн хүнсний агуулах барих ажилд нэмэлт санхүүжилт байгаа юу?

Т.Даваадорж: Өөр асуулт байгаа юу?

П.Мандахбаяр: Өөр асуух асуулт байхгүй ээ.

Г.Оюунмандах: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15,000,000 төгрөгөөр барихаар гэрээ хийсэн. Манайд нэмэлт санхүүжилт авая. Хөрөнгө хүрэхгүй байна гэсэн хүсэлт ирүүлж байгаагүй. 2022 онд дуусаагүй он дамнаж сая дууссан ажил байгаа.

П.Мандахбаяр: Нэмэлт санхүүжилт авъя гэвэл болдог юм уу?

Г.Оюунмандах: Тийм ээ. Санхүүжилт нь хүрэлцэхгүй болсон бол зах зээлийнхээ үнийн судалгаа зэргийг авч ирээд гэрээгээ дахин шинэчилж болдог.

П.Мандахбаяр: За ойлголоо баярлалаа.

Т.Даваадорж: За одоо танхимд ирсэн дарааллын дагуу С.Янжинцэвэл асуултаа асуух цаг явж эхэллээ.

С.Янжинцэвэл: Асуух асуулт байхгүй ээ.

Т.Даваадорж: За М.Энхтуяа таны асуулт асуух ээлж?

М.Энхтуяа: Цэцэрлэгт хүрээлэн гэж хаана байгаа вэ?

Д.Уранчимэг: Төв амралтын цаад талд хашаалаад мод тариад эхэлсэн талбай байгаа. Тэр манай сумын газар цэцэрлэгт хүрээлэн болгож тохижуулахаар зураг төсвийг 4,878,000 төгрөгөөр гаргуулсан.

Т.Даваадорж: За тэгвэл одоо санал хэлэх оролцогчид байна уу?

П.Мандахбаяр: Санал байхгүй.

Т.Даваадорж: За С.Янжинцэвэл санал байна уу?

С.Янжинцэвэл: Санал байхгүй.

Т.Даваадорж: М.Энхтуяа ямар санал байна?


М.Энхтуяа: Санал байхгүй ээ.

Т.Даваадорж: За дэгийн дагуу асуултаа асуулаа, саналаа хэлэх боломж олгосон. Оролцогчдоос санал хэлэх хүн байхгүй учир энэ удаагийн нийтийн сонголт өндөрлөж байна аа.

Хүрэлцэн ирсэн оролцогчдоо болон ажиглагчдаа маш их баярлалаа. Сум орон нутагтаа амьдарч байгаа иргэний хувьд идэвх санаачлагатай байж оролцоог нэмэгдүүлж байгаа та бүхэндээ дахин баярлалаа.

Хурал 15:10 минутад өндөрлөв.

ТАНИЛЦСАН:
ХУРАЛ ДАРГАЛАГЧ  Т.ДАВААДОРЖ

ТЭМДЭГДЭЛ ХӨТӨЛСӨН:
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ЦЭНДХОРЛОО